

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал	10
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	15
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“ХЭРЭМТ ЦАМХАГ” УТҮГ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Н.МӨНХЖАРГАЛ ТАНАА

2020.03.13 № 06/859
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хэрэмт цамхаг” УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол “Хэрэмт цамхаг” УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Хэрэмт цамхаг” УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


Тайлант онд тендер шалгаруулалт хийлгүй 106.5 сая төгрөгийн худалдан авсан ажил үйлчилгээ, нээлттэй тендер шалгаруулалгүй харьцуулалтын аргаар 121.8 сая төгрөгийн бараа, нийт 228.3 сая төгрөгийн худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгээгүй, шүүхийн шийдвэртэй хэдий ч төлбөр барагдахгүй олон жил болсон 34.2 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, мөн дуусаагүй үйлдвэрлэл, бэлэн бүтээгдэхүүний ертгийн тооцоолол алдаатай зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал, Эрх ба үүрэг, Хэмжилт, Үнэлгээ” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

“Хэрэмт цамхаг” УТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хэрэмт цамхаг УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, Хэрэмт цамхаг УТҮГ-ын захирал Н.Мөнхжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөж ажиллах, төрийн өмч болон дахин үнэлгээний нэмэгдэл дансны бүртгэвэл зохих дүнг тодорхойлж өөрчлөлтүүдийг холбогдох баримт бичигт тусгах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хэрэмт цамхаг УТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Хэрэмт цамхаг УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Хэрэмт цамхаг УТҮГ-ын удирдлага санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 03-аас 2020 оны 03 дугаар сарын 09-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Гроут финанс аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Бямба, аудитор Т.Ариунжаргал, аудиторовн туслах М.Насанбат, Э.Нямдорж нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хэрэмт цамхаг УТҮГ -ын 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/88 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хэрэмт цамхаг УТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас дэвшүүлсэн зорилтын хүрээнд үйлдвэрлэлийг хөгжүүлэн үйл ажиллагааных нь үр дүнд хорих ял эдлэгсдийг ажлын байраар хангах, хорих анги, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэс, салбар нэгжийг түшиглэсэн үйлдвэр, үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх замаар дотоод эх үүсвэрийг бий болгоход оршино.

Хэрэмт цамхаг УТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Барилгын материал үйлдвэрлэл
- Оёдлын үйлдвэрлэл
- Гадаад худалдаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол
- Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам батлах тухай" Монгол улсын Засгийн газрын 2019.01.09-ний өдрийн 37 дугаар тогтоол
- Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам" Монгол улсын Засгийн газрын 2019.01.09-ний өдрийн 38 дугаар тогтоол

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Хэрэмт цамхаг УТҮГ нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй байна.

Хэрэмт цамхаг УТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд санхүүгийн unicus программ хангамж ашигладаг байна.

Хэрэмт цамхаг УТҮГ -ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хэрэмт цамхаг УТҮГ -ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 6 чиглэлд 16 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн

орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,160.8 сая төгрөгөөс тооцон 11.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хэрэмт цамхаг УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,478.3 сая төгрөгөөр буюу 47.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,632.4	178.5	(1,453.9)
Авлага	70.9	390.6	319.7
Бараа материал	112.7	33.9	(78.8)
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	-	5.1	5.1
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	88.3	-	(88.3)
Үндсэн хөрөнгө	1,231.6	1,049.5	(182.1)
Нийт хөрөнгө	3,135.9	1,657.6	(1,478.3)
Өр төлбөр	1,511.0	105.4	(1,405.6)
Өмч	1,624.9	1,552.2	(72.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,135.9	1,657.6	(1,478.3)

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө, үндсэн хөрөнгө, өр төлбөр, өмчийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Авлага дансны үлдэгдэл өссөн нь хөнгөн блокны зээлийн борлуулалтаас үүссэн байгууллага болон хувь хүнээс авах авлагын өсөлт нөлөөлжээ. Авлага дансны үлдэгдэлд 2014-2017 онуудад үүссэн, он удаан жил болсон 35.1 сая төгрөгийн байгууллагаас авах авлага байна. 2017, 2018 онуудад анхан шатны шүүхийн албадан гүйцэтгэх шийдвэр гарсан хэдий ч барагдах боломжгүй, эрсдэлтэй 34.2 сая төгрөгийн авлага байна. Энэ нь найдваргүй болох эрсдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь борлуулалт сайн хийгдэж бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэл буурснаас шалтгаалжээ.

Борлуулах зориулалтаар эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгийн дүн 88.3 сая төгрөгөөр буурсан нь бартераар авсан орон сууцны байраа борлуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 182.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардалтай холбоотой байна. Тайлант хугацаанд 0.5 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан.

Мөнгөн хөрөнгө болон өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь өмнөх тайлант хугацааны эцэст хорих ангиудаас орж ирсэн 1,495.2 сая төгрөгийг урьдчилж орсон орлого дансанд бүртгээд, тайлант онд ШШГЕГ руу буцаан шилжүүлсэнтэй холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэлд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын өр болон урьдчилж орсон орлого дансны үлдэгдэл 105.4 сая төгрөг байна.

Өмчийн дансны үлдэгдэл 1,552.2 сая төгрөг болж 72.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны алдагдлаас шалтгаалжээ.

2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Хэрэмт цамхаг УТҮГ тайлант онд 686.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,095.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 59.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Зорилтот түвшний орлого

Орлогын төрөл	/сая төгрөг/			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Борлуулалтын орлого	686.0	1,032.6	346.6	150.5
Бусад орлого		62.4	62.4	
Нийт дүн	686.0	1,095.0	409.0	159.6

Борлуулалтын орлого 346.6 сая төгрөгөөр давсан нь хөнгөн блок 4500м³ үйлдвэрлэхээр төлөвлөсөн боловч 6000м³ үйлдвэрлэж борлуулсантай холбоотой.

Тайлант онд борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 448.0 сая төгрөг, удирдлагын зардалд 189.1 сая төгрөг тус тус төсөвлөсөн.

Гүйцэтгэлээр борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 98 хувийн өсөлттэй буюу 440.5 сая төгрөгөөр хэтэрсэн. Энэ нь борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээний өсөлт, түүхий эд материалын үнийн өсөлттэй холбоотой.

Гүйцэтгэлээр удирдлагын зардал төлөвлөгөөнөөс 48 хувийн өсөлттэй буюу 90.1 сая төгрөгөөр хэтэрсэн. Энэ нь элэгдлийн зардал 68.6 сая төгрөг, дээд шатны байгууллагад төлөвлүүлэх орлогод тооцсон хүү 18.6 сая төгрөгийг төлөвлөгөөнд тусгаагүй, засварын зардал 9.5 сая төгрөгөөр хэтэрсэн зэргээс шалтгаалсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 16 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл нэмж тодорхойлж нийт 18 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 545.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 283.1 сая төгрөгийн алдааг залруулж, 262.5 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө. Үүнд:

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай 283.1 сая төгрөгийн дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, Хэрэмт цамхаг УТҮГ-ын удирдлагаар зөвшөөрүүлэн санхүүгийн тайланг баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайланд авлага, өглөг, орлого, зардлын ангиллыг 109.4 сая төгрөгөөр алдаатай илэрхийлсэн нь Сангийн сайдын 2017 оны 361 тоот тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан тодруулгыг бэлтгэх заавар”-ын ангилалтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулан бүртгэв.

2. Тээврийн хэрэгсэл түрээсийн орлогыг аккруэл сууриар хүлээн зөвшөөрч бүртгээгүй 5.9 сая төгрөг, хүлээлгэн өгсөн бараа материалын борлуулалтыг орлогын дансаар дамжуулан бүртгээгүй 2.7 сая төгрөг нийт 8.6 сая төгрөгийн орлогыг дутуу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1-д “Аж ахуйн нэгж,

байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулан бүртгэв.

3. УТҮГ нь 160.5 сая төгрөгийн байрны эрсдэл, өгөөж нь байгууллагад шилжин ирээгүй байхад борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "Жинхэнэ хэрэгжилтийн", 5.1.4-т "Үнэн зөв байх" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байх, зөв толилуулсан байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулан бүртгэв.

4. ААНОАТ-ын тухай хууль болон аудитын залруулгын нөлөөллийг тусган орлогын албан татварын тооцооллыг хийж компанийн бүртгэсэн татварын зардалтай тулган шалгаж, 4.6 сая төгрөгөөр орлогын албан татварын зардал, өглөгийг нэмэгдүүлэн бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулан бүртгэв.

Аудитаар дараах 545.6 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 262.5 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд хийсэн тендер шалгаруулалт хийлгүй худалдан авсан ажил үйлчилгээ 106.5 сая төрөг, нээлттэй тендер шалгаруулалгүй харьцуулалтын аргаар худалдан авсан бараа 121.8 сая төгрөг, нийт 228.3 сая төгрөгийн худалдан авалтыг хуулийн дагуу хийгээгүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", 5-д "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно" заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөв.

2. Зээлийн борлуулалттай холбоотой үүссэн 34.2 сая төгрөгийн авлагыг албадан гүйцэтгүүлэх шүүхийн шийдвэр 2017, 2018 онуудад гарсан хэдий ч төлбөр барагдуулаагүй хэвээр байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй", 71.1.8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөв

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүйгээс дуусаагүй үйлдвэрлэлийн бүртгэл болон борлуулсан барааны өртгийн тооцоолол хэрхэн бүртгэх талаар тогтоосон горим байхгүй зэрэг нь өртгийг алдаатай илэрхийлэхэд хүргэж байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1.4 дэх заалт "үнэн зөв байх" заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөв

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

2017 болон 2018 онуудад Хорих 407-р ангиас шилжүүлэн урьдчилж орсон сургалтын орлогоор бүртгэсэн 267.4 сая төгрөг, цахилгаан сантехник угсралтын гэрээний орлого 664.8 сая төгрөг, Төв аймгийн хорих ангиас шилжүүлэн урьдчилж орсон сургалтын орлого 318.0 сая төгрөг, 1 цонхны барилгын ажлын орлого 245.2 сая төгрөг буюу нийт 1,495.2 сая төгрөгийг ШШГЕГ-ийн албан тоотын дагуу ШШГЕГ-ийн Удирдах зөвлөлийн дансанд харилцах дансны үлдэгдэлд тооцсон 18.6 сая төгрөгийн хүүгийн орлоготой хамт 1,513.8 сая төгрөг шилжүүлсэн байна.

Энэ асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын хүрээнд авч үзэх шаардлагатай байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хэрэмт цамхаг УТҮГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 178 мэдээллийг 100 хувь хугацаанд нь мэдээлсэн байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байна.

Бараа материалын тайланг гаргахдаа бүтээгдэхүүний үнэ өртгийг буруу тайлагнасан, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт үйлдвэрийн газрын бүртгэл хөтлөх аргачлал тусгаагүйгээс бүтээгдэхүүний өртгийг өөр өөрөөр тооцож, бүртгэлд тусгасан талаарх өмнөх аудитын зөвлөмжүүд хэрэгжээгүй асуудалд албан шаардлага хүргүүлээ.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хэрэмт цамхаг УТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 262.5 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тооцсон 11.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

Хэрэмт цамхаг УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тусган үзүүлэв. Үүнд:

3.1. *Балансын данстай холбоотой асуудал*

3.1.1. *Илрүүлэлт:*

УТҮГ-ын санхүүгийн тайланд төрийн өмчийн дүн 161.1 сая төгрөгөөр тайлагнасан нь компанийн дүрэмд 255.4 сая төгрөг гэж тусгасан байна. Өөрөөр хэлбэл төрийн өмчийн дүн УТҮГ-ын дүрэм болон санхүүгийн тайланд 94.3 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Мөн 2018 оноос өмнөх тайлант үеүдэд бүртгэлтэй байсан дахин үнэлгээний зөрүүгийн бүртгэл зохих нотолгоогоор нотлогдохгүй байна.

Энэ нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.8-д “хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн тухай мэдээлэл, түүнийг бүртгэсэн он, сар, өдөр”, 10.3-т “өөрчлөлт оруулах тухай шийдвэр, бусад баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.1.2 *Эрсдэл:*

Санхүүгийн тайланд төрийн өмчийн дүнг зөрүүтэй илэрхийлэх эрсдэлтэй

3.1.3 *Өгсөн зөвлөмж:*

Төрийн өмч болон дахин үнэлгээний нэмэгдэл дансны бүртгэвэл зохих дүнг тодорхойлж холбогдох өөрчлөлтүүдийг санхүү бүртгэл, баримт бичигт оруулах.

3.1.4 *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

Дахин үнэлгээний зөрүүгийн өөрчлөлтийг холбогдох материалыг бүрдүүлж улсын бүртгэлд бүртгүүлж, байгууллагын гэрчилгээнд өөрчлөлтийг оруулна.

3.2. Балансын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөж ажиллаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох стандарт, хууль журам зааврыг мөрдөж ажиллаагүй байх;

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөж ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өөрийн үйлдвэрийн үйл ажиллагаанд нийцүүлсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан**4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1,632,357,321.89	178,537,096.56
1.1.2	Дансны авлага	70,387,414.40	361,210,554.63
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	6,493.84	25,855,951.10
1.1.4	Бусад авлага	500,000.00	3,490,909.09
1.1.5	Бараа материал	112,655,883.55	33,882,891.20
1.1.6	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	5,089,737.50
1.1.7	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө	88,306,818.18	-
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,904,213,931.86	608,067,140.08
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,231,023,914.24	1,049,239,356.70
1.2.2	Биет бус хөрөнгө	626,602.56	299,679.48
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,231,650,516.80	1,049,539,036.18
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,135,864,448.66	1,657,606,176.26
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	5,000,000.00	-
2.1.1.2	Татварын өр	10,820,627.96	6,880,145.03
2.1.1.3	Урьдчилж орсон орлого	1,495,207,749.95	98,510,900.00
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,511,028,377.91	105,391,045.03
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,511,028,377.91	105,391,045.03
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	161,096,688.93	161,096,688.93
2.3.2	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,837,618,788.49	1,837,618,788.49
2.3.3	Хуримтлагдсан ашиг	(373,879,406.67)	(446,500,346.19)
	Эздийн өмчийн дүн	1,624,836,070.75	1,552,215,131.23
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,135,864,448.66	1,657,606,176.26

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөр	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого	1,663,339,949.68	1,032,643,472.70
2	Борлуулалтын өртөг	(1,498,461,035.21)	(888,522,304.24)
3	Нийт ашиг(алдагдал)	164,878,914.47	144,121,168.46
4	Хүүгийн орлого	41,525,559.88	35,138,923.09
5	Бусад орлого	16,603,528.94	27,225,021.13
6	Борлуулалт маркетингийн зардал	(2,564,545.46)	(2,536,363.66)
7	Ерөнхий ба удирдлагын зардал	(92,739,780.23)	(141,400,857.56)
8	Бусад зардал	-	(6,405,673.90)
9	Бусад ашиг (алдагдал)	(15,687,576.22)	(118,570,480.25)
10	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	112,016,101.38	(62,428,262.69)
11	Орлогын татварын зардал	(12,954,133.94)	(10,192,676.83)
12	Татварын дараах ашиг (алдагдал)	99,061,967.44	(72,620,939.52)
13	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
14	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	99,061,967.44	(72,620,939.52)
15	Бусад дэлгэрэнгүй орлого		
16	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
17	Орлогын нийт дүн	1,721,469,038.50	1,095,007,416.92
18	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөр	ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,128,395,660.73	991,366,706.09
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	442,155,500.00	797,324,900.00
1.1.2	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	56,519.00	
1.1.3	Бусад мөнгөн орлого	1,686,183,641.73	194,041,806.09
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,611,333,597.43	2,361,755,374.26
1.2.1	Ажиллагчдад төлсөн	121,591,387.90	147,519,422.45
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,559,382.67	3,311,736.81
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,280,040,599.16	362,101,830.58
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	16,526,212.61	35,713,792.75
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	109,327,385.00	111,908,510.00
1.2.6	Татварын байгууллагад төлсөн	57,330,093.09	110,629,700.64
1.2.7	Даатгалын төлбөрт төлсөн	540,490.00	903,960.00
1.2.8	Бусад мөнгөн зарлага	23,418,047.00	1,589,666,421.03
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	517,062,063.30	(1,370,388,668.17)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	41,525,559.88	35,138,923.09
2.1.1	Хүлээн авсан хүүгийн орлого	41,525,559.88	35,138,923.09
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	41,525,559.88	35,138,923.09
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	80,000,000.00	118,570,480.25
3.2.1	Бусад	80,000,000.00	118,570,480.25
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(80,000,000.00)	(118,570,480.25)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	478,587,623.18	(1,453,820,225.33)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,153,769,698.71	1,632,357,321.89
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,632,357,321.89	178,537,096.56

4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	161,096,688.93	1,297,769,167.27	(472,941,374.11)	985,924,482.09
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			99,061,967.44	99,061,967.44
4	Дахин үнэлгээний нэмэгдэл		539,849,621.22		539,849,621.22
5	2018 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	161,096,688.93	1,837,618,788.49	(373,879,406.67)	1,624,836,070.75
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
7	Залруулсан үлдэгдэл				-
8	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(72,620,939.52)	(72,620,939.52)
9	2019 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	161,096,688.93	1,837,618,788.49	(446,500,346.19)	1,552,215,131.23

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Хэрэмт цамхаг УТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код:
2020.03.13			САГ-2020/60/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хэрэмт цамхаг УТҮГ		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хууль зөрчсөн	228.3	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал Нягтлан бодогч	Н.Мөнхжаргал Т.Чулуунцэнд
2	Шүүхийн албадан гүйцэтгүүлэх шийдвэр гарсан хэдий ч төлбөр барагдуулаагүй олон жилийн насжилттай авлага бүртгэлд туссан	34.2	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал Нягтлан бодогч	Н.Мөнхжаргал Т.Чулуунцэнд
3	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ компанийн дүрэм болон санхүүгийн тайланд төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн. Мөн 2018 оноос бүртгэлтэй байсан дахин үнэлгээний зөрүүгийн бүртгэл зохих нотолгоогоор нотлогдохгүй байна.		Зөвлөмж	Гүйцэтгэх захирал Нягтлан бодогч	Н.Мөнхжаргал Т.Чулуунцэнд
4	Өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөөгүй		Зөвлөмж	Гүйцэтгэх захирал Нягтлан бодогч	Н.Мөнхжаргал Т.Чулуунцэнд
	Дүн	262.5			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 20 № 02/145
СМГ-2020/60/СТА-ТӨЧГ

Улаанбаатар хот

Г Зөрчил арилгуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хэрэмт цамхаг” УТҮГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд хийсэн тендер шалгаруулалт хийлгүй худалдан авсан ажил үйлчилгээ 106.5 сая төрөг, нээлттэй тендер шалгаруулалгүй харьцуулалтын аргаар худалдан авсан бараа 121.8 сая төгрөг, нийт 228.3 сая төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 8.4-д “Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”, 8.5-д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” заалтууд,
2. Зээлийн борлуулалттай холбоотой үүссэн 34.2 сая төгрөгийн авлагыг албадан гүйцэтгүүлэх шүүхийн шийдвэр 2017, 2018 онуудад гарсан хэдий ч төлбөр барагдуулаагүй хэвээр байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй”, 71.1.8-д “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх” гэсэн заалтууд,
3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүйгээс дуусаагүй үйлдвэрлэлийн бүртгэл болон борлуулсан барааны өртгийн тооцоолол хэрхэн бүртгэх талаар тогтоосон горим байхгүй зэрэг нь өртгийг алдаатай илэрхийлэхэд хүргэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт “Үнэн зөв байх” заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т заасан “аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie_Kherep\Alban_Shaardлага\2020\03195AG2.Docx

001080484

1. Худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулах, найдваргүй авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, дуусаагүй үйлдвэрлэл болон борлуулсан барааны өртгийг үнэн зөв тооцох зэрэг нийт 262.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэхийг "Хэрэмт цамхаг" УТҮГ-ын гүйцэтгэх захирал Н.Мөнхжаргал, нягтлан бодогч Т.Чулуунцэнд нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

<p>ТОГТООСОН: САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР</p> <p><i>[Signature]</i> Ц.НАРАНЧИМЭГ</p> <p>АУДИТОР</p> <p><i>[Signature]</i> Д.ЦЭГМИДДОРЖ</p> <p>ГРОУТ ФИНАНС АУДИТ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ</p> <p><i>[Signature]</i> Б.БЯМБА</p>	<p>ЗӨВШӨӨРСӨН: ХЭРЭМТ ЦАМХАГ" УТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ</p> <p><i>[Signature]</i> (Мөнхжаргал) Н.МӨНХЖАРГАЛ</p> <p>НЯГТЛАН БОДОГЧ</p> <p><i>[Signature]</i> Т.ЧУЛУУНЦЭНД</p>
--	---

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

ТЭМДЭГЛЭЛ

A series of 30 horizontal dotted lines for writing a conclusion.